

НИЙСЛЭЛИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ ИЛТГЭХ ХУУДАС

2024 оны 05 сарын 10 өдөр

Дугаар №2

Багануур дүүрэг

Төв аймгийн Батсүмбэр, Баянчандмань, Жаргалант сумын нутагт ЗӨСҮТ-тэй хамтран хийх хачиг болон хачгаар дамжих халдварт өвчний үүсгэгчийн тархалтыг тогтоох тандалт судалгаа

Нэг. Үндэслэл:

1.1 Хачгаар дамжих халдварт өвчний байгалийн голомтын тандалт судалгааны үр дүн нь хүн амыг байгалийн голомтот зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх, гүйцэтгэхэд чухал үндэс суурь нь болдог. Манай дэлхий дээр *Ixodidae* овгийн 14 төрлийн 899 орчим зүйлийн хачиг тархалттай байдаг. Монгол улсад 5 төрөлд хамаарах 16 зүйлийн иксод, 1 төрөл, 1 зүйлийн аргаз хачиг тархсан нь тодорхойлогдсон.

Монгол улсад тархсан хачгуудаас *Ixodes persulcatus*, *Dermacentor nuttalli* зүйлийн хачгууд зоонозын гаралтай халдварт өвчний агуулагч, дамжуулагч нь болж хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Хачгаар дамжих халдварт өвчний хүний өвчлөлийн тохиолдол 2005-2021 онд нийт хүний өвчлөлийн 1952 тохиолдол бүртгэгдэж, 20 тохиолдол нь нас барсан.

1.2 Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн статистик мэдээлэлд улсын хэмжээнд 2023 онд хачигт халдварын 556 дуудлага хүлээн авснаас хачигт риккетсиоз 416, онош батлагдсан 141, хачигт энцефалит 100, онош батлагдсан 37, нас барсан 3, хачигт боррелиоз 40, онош батлагдсан 3 тохиолдол бүртгэгдсэн. 2023 онд бүртгэгдсэн Хачигт халдварын өвчлөл 10.000 хүн амд 0.6 болж өмнөх оноос 0.2-оор өссөн байна.

Сүүлийн жилүүдэд Төв аймгийн сумдад хачигт хазуулан халдвар авсан иргэдийн тоо нэмэгдэж байна. 2009 оноос хойш хачиг риккетсиозын 30 гаруй тохиолдол; 2016, 2017 онд хачигт энцефалитын 5 тохиолдол, 2008, 2018, 2019, 2020 онд хачигт боррелиозын 7 тохиолдол бүртгэгдээд байна. 2022 онд ЗӨСҮТ-өөс Төв аймгийн 6 сумыг хамруулсан хачгаар дамжих халдварт өвчний тандалт судалгааг хийсэн. Судалгааны дүнд 51 хүний цуснаас сорьц авч шинжилгээ хийхэд анзаарагддаггүй халдвар болох анаплазмозын халдвар хамгийн их буюу 8 иргэнд илэрсэн.

1.3 Тайгын хачгийн тархалтыг Батсүмбэр сумаас 1 цэгт, Жаргалант сумаас 2 цэгт газар шинээр тэмдэглэж, цуглуулсан хачганд шинжилгээ хийхэд 93.7% нь хачигт риккетсиоз, 1.34% нь анаплазмоз өвчний халдвартай болох нь тогтоогдсон.

Иймээс тус бүс нутагт хачгаар дамжин халдварладаг түгээмэл халдваруудаас гадна анзаарагддаггүй халдварын тандалт судалгааг эрчимжүүлэн тогтмол хийх шаардлагатай байна.

Хоёр. Ажилласан бүрэлдэхүүн:

4.1 ЗӨСҮТ-ийн судалгааны баг: Амьтан судлагч Д.Батжав, Шимэгч судлагч Б.Болорчимэг, Амьтан судлагч М.Даваадорж, Халдвар судлагч их эмч Б.Цэцэг Хээрийн шинжилгээний жолооч Ч.Лхагвасүрэн.

4.2 НЗӨСТ-ийн судалгааны баг: Амьтан судлагч Б.Учрахбаяр, Шимэгч судлагч Б.Мөнгөнбагана, Нян судлагч Б.Ганбилэг, Хээрийн шинжилгээний жолооч М.Баярсайхан нар хийж гүйцэтгэнэ.

Гурав. Хийж гүйцэтгэсэн ажил:

3.1. Хачиг болон хачгаар дамжих халдварын үүсгэгчийн тархалтыг тогтоох тандалт судалгааг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 04-ний өдрүүдэд Төв аймгийн Батсүмбэр, Баянчандмань, Жаргалант, Баянцогт сумын нутагт маршрутын дагуу Nissan Urvan, Hyundai Tucson маркийн 2

авто машинаар тус бүр 1286 км, нийт 2572 км зам туулж ЗӨСҮТ-ийн 5, НЗӨСТ-ийн 4, нийт 9 мэргэжилтнүүд хамтран хийлээ.

3.2. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/161 тушаал “Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгааллын дэглэм, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн заавар”, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирлын 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/10 тушаал “Хачгаар дамжих халдварт өвчний байгалийн голомтын тандалт судалгааны заавар”-ыг баримтлан хачгаар дамжих халдварын байгалийн голомтын судалгааг хайгуул хэлбэрээр Төв аймгийн Батсүмбэр, Баянчандмань, Жаргалант сумын нутагт талбайн биотопыг харгалзаж 9 цэгт газрыг сонгон судалгааг хийж гүйцэтгэсэн. Төв аймгийн Батсүмбэр, Баянчандмань, Жаргалант сумын судалгаанд хамрагдсан цэгт газрын биотоп нь Хэнтий нурууны уулсын энгэр, хажуугийн нугат ойн-гүн цэвдэгт хөрстэй, өвслөг ургамалт хус-шинэсэн-нарсан ой, уулын хөндий, энгэр, хажуугийн хормой дагасан алаг өвс-улалж-жигж дэгнүүлт үетэнт уулын нугын хээр бүхий нутгаас *Ixodes* төрлийн 1 зүйл хачиг, *Dermacentor* төрлийн 1 зүйлийн хачиг цуглуулсан.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Захирлын 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/10 дугаар тушаал “Хачгаар дамжих халдварт өвчний байгалийн голомтын тандалт судалгааны заавар”-ын 2.2.1 дэх заалтыг үндэслэн *I. persulcatus* зүйлийн 65 хачиг, *D. nuttalli* зүйлийн 288 хачиг, нийт 353 ширхэг хачиг цуглуулсан.

Зураг 1. Дарцгийн аргаар хачиг цуглуулж, бичил цаг уурын хэмжилт хийж байгаа нь.



Тандалт судалгааны үеэр цэгт газруудаар өдрийн 09-17 цагийн хооронд агаарын дундаж температур 14,3°C, салхины дундаж хурд 1,6м/с, агаарын дундаж чийгшил 34,1%, хөрсний дундаж чийгшил 37,2% байсан. Цуглуулсан хачиг бүгд бие гүйцсэн *I. persulcatus*, *D. nuttalli* зүйлийн хачиг байв. Хачиг цуглуулсан цэгт газар байршлыг Хүснэгт 1 -т үзүүлэв.

Хүснэгт 1.

№	Сум	Газрын нэр	Сектор дугаар	Хачиг цуглуулсан замналын урт /км/	Хачиг түүсэн нийт цаг	Цуглуулсан хачигны зүйл	Тоо /ш/	Хүйс
1	Батсүмбэр	Үдлэг	3314814222	10	4	<i>I. persulcatus</i>	7	эр
2			3314814222	10	4	<i>I. persulcatus</i>	8	эм
3			3314814222	10	4	<i>D. nuttalli</i>	1	эр
4			3314814222	10	4	<i>D. nuttalli</i>	7	эм

5	Батсүмбэр	Сөгнөгөр	3314813044	10	4	I.persulcatus	11	эр
6			3314813044	10	4	I.persulcatus	10	эм
7			3314813044	10	4	D.nuttalli	2	эр
8			3314813044	10	4	D.nuttalli	1	эм
9	Жаргалант	Хоолтын ам	3314812841	10	4	I.persulcatus	10	эр
10			3314812841	10	4	I.persulcatus	13	эм
11			3314812841	10	4	D.nuttalli	2	эм
12	Жаргалант	Хустайн ам	3314812844	10	4	I.persulcatus	2	эр
13	Жаргалант		3314812844	10	4	I.persulcatus	2	эм
14	Баянчандмань	Сумын баруун хойно	3314814124	10	4	D.nuttalli	5	эр
15			3314814124	10	4	D.nuttalli	10	эм
16	Баянцогт	Их булаг	3314814144	10	4	D.nuttalli	110	эр
17			3314814144	10	4	D.nuttalli	150	эм

Батсүмбэр, Жаргалант сумын Хус-Шинэсэн ой бүхий биотопид ойн улаан хачиг тархалтай байгааг тогтоосон. Жаргалант сумын Хоолтын аманд улаан хачгийн тоошил өндөр байсан. Судалгаанд хамрагдсан газар нутагт ноёлох салхины чиглэлийн дагуу хачигны тоошил өсөх хандлагатай байсан.

3.3 Төв аймгийн Батсүмбэр, Жаргалант сумын эрсдэлт бүлгийн иргэдийн хачигт халдварын мэдлэг, дадал хандал, эрсдэлийг үнэлэх зорилгоор Зоонозын өвчин судлалын төвийн 2016 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/17 дугаар тушаалын дагуу 150 иргэнээс асуумж судалгааг авч, хачигнд хазуулсан гэх өгүүлэмжтэй 22 иргэнээс цус авч ажилласан.

Зураг 2. Асуумж судалгаа авч байгаа нь.



ХЯНАСАН:

ХАЛДВАР СУДЛАГЧ ЭМЧ

А.МӨНХТУУЛ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ШИМЭГЧ СУДЛАГЧ

Б.МӨНГӨНБАГАНА